



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар

A/789

Ховд

Зарим төрлийн согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх цагийн хуваарь тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, үйлчилгээний төв, дэлгүүр, баар, караоке, ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2021 оны 01 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хатуулаг багатай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхээр цагийн хуваарийг 09:00 цагаас 22:00 цагийн хооронд байхаар тогтоосугай.

2. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ